



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:92-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА Б.ЧОЙЖИЛСҮРЭН  
ТАНАА

2019.05.16 № 1045

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр "Цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудитор, түүний орлогч нарыг дээрх тогтоолын төслийн 1-д "...Төрийн аудитын байгууллагын дарга, Дэд дарга..." гэж томъёолон итгэлцүүрт хамаарахгүй байхаар тусгажээ.

Энэхүү тогтоол батлагдсанаар Монгол Улсын Их Хурлын 2019 оны 19 дүгээр тогтоолын ТӨ-IVA зэрэглэлд хамаардаг Монгол Улсын Ерөнхий Аудитор, ТӨ-VIA зэрэглэлд хамаардаг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч нарын цалингийн асуудал орхигдож, Төрийн аудитын тухай хууль болон Төрийн албаны тухай хууль хэрэгжихгүй нөхцөл үүсэхээр байна.

УИХ-аас 2003 онд батлагдсан Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.11-д "Монгол Улсын Ерөнхий аудиторын цалин, зэрэг зиндааг Улсын Их Хурал тогтооно", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцоо төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд өөрийн онцлогт тохирсон байх бөгөөд тэдгээрийн албан тушаалын цалингийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно" гэж хуульчилсан байдаг боловч одоогоор Монгол Улсын Ерөнхий аудитор болон төрийн аудитын байгууллагын ажилтнуудын цалин хөлсийг УИХ-аас тогтоогоогүй байна.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг хараат бусаар хэрэгжүүлэх, албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний нийгмийн баталгааг хангах үүднээс Монгол Улсын Ерөнхий аудитор болон төрийн аудитын байгууллагын ажилтнуудын албан тушаалын цалингийн хэмжээг УИХ-д өргөн барихаар Төрийн албаны зөвлөл болон МУ-ын Засгийн газарт хандаж Төрийн албаны тухай хуульд заасны дагуу зөвшилцөн холбогдох саналыг бичгээр авсан болно.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.11, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудитор болон төрийн аудитын байгууллагын ажилтнуудын албан тушаалын цалингийн хэмжээг УИХ-аар тогтоолгохоор холбогдох саналыг хүргүүлж байна.

Зохих журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Хавсралт 7 хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ



10.19.10.25 Bichig\_Khereg\Yawsan\_Bichig\2019\0516TG2 Docx

070001

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ

Дугаар \_\_\_\_\_

201 \_\_\_\_ сарын \_\_\_\_ ны өдөр  
хот

Төрийн ордон, Улаанбаатар

Төрийн аудитны байгууллагын албан хаагчдын албан тушаалын  
цалингийн хэмжээг тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 57.2.3 дахь заалт, Төрийн  
аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.11, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг тус  
тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалингийн  
хэмжээг хавсралтаар тогтоосугай.

2. Энэ тогтоолыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН  
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Албан тушаал	Албан тушаалын сарын цалингийн хэмжээ /төгрөгөөр/
1	Монгол Улсын Ерөнхий аудитор	1879350
2	Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч	1768000
3	Үндэсний аудитын Тамгын газрын дарга	1683000
4	Үндэсний аудитын газрын Төрөлжсөн аудитын газрын захирал	1657500
5	Үндэсний аудитын газрын аудитын менежер, хэлтэс, албаны дарга	1572500
6	Үндэсний аудитын газрын ахлах аудитор, ахлах шинжээч	1530000
7	Үндэсний аудитын газрын аудитор, шинжээч	1487500
8	Орон нутаг дахь Төрийн аудитын газрын дарга	1572500
9	Орон нутаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер, хэлтсийн дарга	1530000
10	Орон нутаг дахь Төрийн аудитын газрын аудитын ахлах аудитор, ахлах шинжээч	1487500
11	Орон нутаг дахь Төрийн аудитын газрын аудитын аудитор, шинжээч	1445000



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА Д.ХҮРЭЛБААТАР ТАНАА

МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,  
Утас: 264216, Факс: 264460,  
E-mail: info@csc.gov.mn

2017.12.19 № 1395


танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Санал өгөх тухай

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс санал авахаар Танаас ирүүлсэн "Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын цалингийн хэмжээ тогтоох тухай" болон "Төрийн аудитын байгууллагын албан хаагчид нэмэгдэл олгох журам батлах тухай" Улсын Их Хурлын тогтоол, журмын төсөлтэй танилцлаа.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг хараат бусаар хэрэгжүүлэх болон тус байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах үүднээс цалин, нэмэгдлийг шинэчлэх талаар боловсруулсан Улсын Их Хурлын тогтоол, журмын төслийг зарчмын хувьд дэмжиж байна.

ДАРГА



Б.ЦОГОО



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2019.05.16 № 4-3/3084

тантай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА  
Б.ЧОЙЖИЛСҮРЭН ТАНАА**

Монгол Улсын Ерөнхий Аудитороос 2019 оны 05 дугаар сарын 14-ний өдөр "Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулан ирүүлээд байна.

Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын цалингийн хэмжээг тогтоохдоо Улсын Их Хуралд үйл ажиллагаагаа тайлагнадаг бусад байгууллагуудын цалингийн хэмжээтэй адилтгах замаар 2019 оны төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй байхаар тогтоох саналыг дэмжиж байна.



Ч.ХҮРЭЛБААТАР

## ТАНИЛЦУУЛГА

### “Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн тухай

Төрийн аудитын байгууллага нь төрийн хяналтын байгууллага бөгөөд Төрийн эрх барих дээд байгууллагын үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, эх орон, ард түмний эрх ашгийн төлөө Засгийн газрын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд туслах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Их Хурлаас 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр баталсан Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн хэрэгжиж эхэлснээр төрийн аудитын тогтолцоо шинэчлэгдэн, нэгдсэн бүтэц зохион байгуулалтад орж төрийн аудитын байгууллагын эрхлэх ажлын цар хүрээ, чиг үүрэг өргөжсөн.

Тус байгууллага нь 2018 онд санхүүгийн тайлангийн аудитын 3806, гүйцэтгэлийн 201, нийцлийн 97, нийт 4104 аудит гүйцэтгэж, 18,8 их наяд төгрөгийн зөрчил илрүүлж, 15.2 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн бөгөөд зөвхөн санхүүгийн тайлангийн аудитаар тооцож үзэхэд нэг аудитор, шинжээч жилд дунджаар 27 байгууллагын санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэж байгаа нь өндөр ачаалалтай ажиллаж буйг илтгэж байгаа юм.

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.11, “Монгол Улсын Ерөнхий аудиторовын цалин, зэрэг зиндааг Улсын Их Хурал тогтооно.”, 14 дүгээр зүйлийн 14.4.-т “Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын цалингийн хэмжээг УИХ тогтооно.” гэсэн зохицуулалт өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй, төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох шийдвэр гараагүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7<sup>1</sup>.1, 7<sup>1</sup>.2-т төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын Ерөнхий аудитор, тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээчээс бүрдэнэ, эдгээр албан хаагч нь төрийн тусгай албан хаагч байна хэмээн заасан боловч дээрх хууль тогтоомжийн дагуу Төрийн аудитын байгууллагын төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээг тогтоосон эрх зүйн акт байхгүй тул Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2-т заасан төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээг баримталж иржээ.

Судалгаагаар Үндэсний аудитын газрын нэг албан хаагчийн албан тушаалын дундаж цалин Ерөнхий прокурорын газрын албан тушаалын дундаж цалингаас 14 орчим хувиар, Авлигатай тэмцэх газрын албан тушаалын дундаж цалингаас 24 орчим хувь, Шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалын дундаж цалингаас 54.0 хувиар тус тус бага байна.

Улсын Их Хурлын 2019 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалын зэрэглэлээр Монгол Улсын Ерөнхий аудиторовын албан тушаалын зэрэглэл нь ТӨ-IVA-д заасан адилтгах албан

тушаалын зэрэглэлд хамрагдаж байгаа бөгөөд ТӨ-IV-д заасан Монгол Улсын Ерөнхий прокурорын албан тушаалын ангилал зэрэглэлтэй адилтгасан байна.

Төрийн аудитын байгууллагын албан хаагчид нь дээрх байгууллагуудын албан хаагчийн адил нотлох баримт бүрдүүлж, үнэлэлт дүгнэлт өгч, холбодох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар зөвлөмж гарган, алдаа зөрчлийг арилгах талаар хугацаатай акт, албан шаардлага өгч ажилладаг төрийн тусгай албан хаагчид юм. Өөрөөр хэлбэл хөндлөнгийн нөлөөнд үл автан хараат бусаар аудитын үйл ажиллагааг явуулах үүрэгтэй. Аудитын шалгалтаар илэрсэн зөрчлийн нотлох баримтад тулгуурлан хууль хүчний байгууллагууд мөрдөн шалгах үйл ажиллагааг явуулдаг байна.

Иймд “Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахдаа дараах тогтоол, шийдвэрийг мөрдлөгө болгон авч үзсэн болно. Үүнд:

1. “Монгол Улсын прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын 2016 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан Прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг 15 хувиар бууруулж, Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын суурь цалингийн хэмжээг тооцов. Тооцоог хавсаргав.

2. Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг тогтоохдоо Төрийн аудитын тухай хуульд заасан албан тушаалын нэршлийг үндэслэл болгов.

Энэхүү тогтоол батлагдсанаар Төрийн аудитын байгууллагыг мэргэжлийн чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлэх, улмаар олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөж аудит хийх, мэргэжлийн өндөр түвшинд дүгнэлт гаргадаг болох, ажилтнуудын тогтвор, суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, хараат бус байдал хангагдана.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГСДЫН ЦАЛИНГ  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН АЖИЛТНУУДЫН  
ЦАЛИНТАЙ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

/төгрөг/

дд	Төрийн аудитын байгууллага			Улсын ерөнхий Прокурорын газар		Зөрүү
	Албан тушаал	Одоогийн үндсэн цалин	Нэмэгдүүлэх Үндсэн цалин	Албан тушаал	Үндсэн цалин	
1	Монгол Улсын Ерөнхий аудитор	1,700,443	1,879,350	МУ-ын Ерөнхий прокурор	2,211,000	(331,650)
2	МУЕА-ын орлогч бөгөөд тэргүүлэх аудитор	1,506,432	1,768,000	МУ-ын Ерөнхий прокурорын орлогч	2,080,000	(312,000)
3	Үндэсний аудитын газрын тамгын газрын дарга	1,141,237	1,683,000	МУ-ын Ерөнхий прокурорын туслах	1,980,000	(297,000)
4	Үндэсний аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор	1,121,448	1,657,500		1,950,000	(292,500)
5	Үндэсний аудитын газрын хэлтэс, албаны дарга, аудитын менежер	1,074,333	1,572,500		1,850,000	(277,500)
6	Үндэсний аудитын газрын ахлах аудитор, ахлах шинжээч	1,051,930	1,530,000		1,800,000	(270,000)
7	Үндэсний аудитын газрын аудитор, шинжээч	964,207	1,487,500		1,750,000	(262,500)
8	Орон нутаг дахь төрийн аудитын газрын дарга	1,062,473	1,572,500	Нийслэлийн прокурор	1,850,000	(277,500)
9	Орон нутаг дахь төрийн аудитын газрын хэлтсийн дарга, аудитын менежер	1,019,469	1,530,000	Нийслэлийн прокурорын орлогч	1,800,000	(270,000)
10	Орон нутаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор, ахлах шинжээч	962,458	1,487,500	Нийслэлийн ерөнхий прокурорын туслах	1,750,000	(262,500)
11	Орон нутаг дахь төрийн аудитын газрын аудитор, шинжээч	843,133	1,445,000	Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор	1,700,000	(255,000)